



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

“Ингүүмэл-Инвест ББСБ” ХХК-д  
банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ингүүмэл-Инвест ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тус тус тэмдэглүүлж, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримт бичгийг 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ингүүмэл-Инвест ББСБ” ХХК /Д.Энэбиш/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

00000